

Монгол хэлний төрөл садны нэрийн анхдагч бүтцүүд

Д.Соронзон (Ph.D), Ч.Дүүрэнжаргал (магистр)
 Монгол Улс. Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Аливаа хэлний төрөл садны нэрс нь тухайн хэлнийхээ уугуул үгийн сангийн бүрэлдэхүүнд маш эрт үеийн онцлогийг хадгалан хэрэглэгддэг. Иймээс эдгээр нэр нь төрөл хэлнүүдийн гарлын холбоог тогтооход чухал баримт болдог байна.

Монгол хэлний төрөл садны нэрс нь утга, бүтцийн талаас олон мянган жилийн турш хувьсаж хөгжиж ирэхдээ монголчуудын нийгмийн хөгжлийн үе шатны онцлог шинжүүдийг өөртөө шингээсэн нэрлэлтийн өвөрмөц нэгэн тогтолцоог бий болгожээ.

Эдгээр нэр нь судлаачдын сонирхлыг зүй ёсоор татаж, улмаар судалгаа шинжилгээний ажил цөөнгүй хийгдсэн боловч, тэдгээрт гол төлөв төрөл садны нэрсийн утга агуулга, бүрэлдэхүүнийг тодорхойлох талын судалгаа давамгайлжээ. Харин гарал, бүтцийн талыг нь судалсан зүйл харьцангуй бага байна.

Монгол хэлний төрөл садны нэрсийн бүтсэн аргыг ажиглавал, тэдгээрийн зарим нь түрэг, манж-түнгүс хэлнүүдэд тохиолдох үгстэй хэлбэр, утгын талаар дүйж байхад, нөгөө хэсэг нь зөвхөн монгол хэл, аялгуунуудад тохиолддог онцлогтой.

Эхний хэсэгт багтах үгс нь хүн төрөлхтний хэлний нийтлэг үзэгдэл боловч, бүтэц, утгын хувьсал, уламжлагдсан байдал зэргээрээ алтай язгуурын хэлнээс уламжилсан ул мөрийг төрөл хэлнүүдэд үлдээжээ. Тодруулбал, эдгээр нэр нь алтайн өвөг хэлний үед язгуур давтах замаар үүссэн байх бөгөөд монгол хэлний төрөл садны нэрсийн дотроос хамгийн эртний гаралтай юм. Цаашид эдгээр нэр нь зохих үг, бүтээвэртэй холбогдож үгийн сангийн шинэ нэрлэлтийг үүсгэж ирсэн байна.

Тус өгүүлэлд бид өвөг алтайн хэлний үед үүссэн монгол хэлний нэрсийг түүвэрлэн авч анхдагч бүтэц, утгыг сэргээн тогтоож, түрэг, манж-түнгүс хэлний баримтуудтай харьцуулан үзүүлэв.

	Монгол хэл, аялгуу, бичгийн дурсгалуудад тохиолдох төрөл садны нэрсийн бүтэц, утга	Сэргээсэн хэлбэрийн түүхэн бүтэц, утга	Холбогдсон үг, бүтээврийн түүхэн бүтэц, утга, үүрэг	Түрэг, манж-түнгүс хэлний баримтууд
“ma” үе бүтээврийн давталтаас үүссэн нэрс				
1.	ma:ma: (Khal, Bur.) “ээж”	*mama “ээж”		cf. mama “ээж” (Ma, T, Kaz, Kir, Tat, Öz, Uig, Trkm, Yak.)
2.	ama ~ a:ma (Mngr, Khush.) “ээж”	*mama “ээж”		
3.	- amo (Bao.) “ээж”	*mama “ээж”		
“me” үе бүтээврийн давталтаас үүссэн нэрс				
4.	meme (SY.), me:me (Tum.) “ээж”	meme “ээж”		
5.	- mō:mō: (Khar.) “ээж”	meme “ээж”		
6.	- mō:m (Barin.) “ээж”	meme “ээж”		
7.	eme: (Tum.) “ээж”	meme “ээж”		
8.	emege (Mo.) “эмэг”	eme “ээж”	ge “хүн”	cf. eme “ээж” (Ma.)
9.	mugen (Mngr.) “эмгэн”	eme “ээж”	gü “хүн”-/n/ ¹	
10.	emügen (MM.) “эмгэн”	eme “ээж”	gü “хүн”-/n/	

¹ Тэмдэг нэр бүтээх дагавар

11.	eme (Mo.) “эмэгтэй”	meme “эмэгтэй”		
“на” үе бүтээврийн давталтаас үүссэн нэрс				
12.	nä:nä: (ÖMon.) “бабка по матери”	ana “ээж”	ana “ээж”	cf. ana “ээж” (Kaz, Tat, KТat, KKal, KBal, Öz, Uig, Trkm, Yak.), anai (Dun.)
13.	ana (Dun.) “ээж”	*nana “ээж”		
14.	angya (SY.) “эмэг эх”	ana “ээж”	γa “хүн”	
15.	naγa (Ord.) “нагац”	ana “ээж”	γa “хүн”	
16.	naγai (Mngr.) “нагац”	ana “ээж”	γa(i) “хүн”	
17.	naγaγu (Mo.) “нагац”	naγa “нагац”	γu “хүн”	
18.	naγasaγai (Tson.) “нагац эгч нар”	naγaγu “нагац”	γai “эмэгтэй хүн”	
19.	naχtsäγä (Oir.) “нагац”	naγaγu “нагац”	aγa “ах/хүн”	
20.	än'a: (Khal.) “эгч”	ana “эгч”		
“не” үе бүтээврийн давталтаас үүссэн нэрс				
21.	nene (Baο.) “эмгэн”	*nene “ээж”		
22.	nieniegie (Dun.) “эмгэн”	*nene “ээж”	ge “хүн”	
“ба” үе бүтээврийн давталтаас үүссэн нэрс				
23.	ba:w (Kal.) “ээж”	*baba “ээж”		
24.	ba:wǵa (Kal.) “бабушка”	*baba “ээж”	γa “хүн”	
25.	aw'a: ~ ewe: (Min.) “ээж”	*aba/*ebe “ээж”		
26.	ba:wai (Tson.) “эгч”	*baba “эгч”		
27.	abayai (Bur.) “эгч”	*aba “эгч”	γai “хүн”	cf. apa “эгч” (AT, KKal.), apä (öz.), appa (Chuv.)
28.	abaža: (Aga.) “эгч”	*aba “эгч”	*ada < *dada “эгч”	
29.	baĵa (Mo.) “баз” ²	*aba “эгч”	*ada “нөхөр”	
30.	- baĵalin (?) “базууд”	baĵa “баз”	li(n) “төрөл сад хүн”	
31.	abadži ~ abdži: (Ord.) “эгч”	*aba “эгч”	*ada < *dada “эгч”	
32.	abisun (Mo.) “авьсан” ³	*aba “эгч”	*sīn “охин дүү” (< AT.)	
33.	- abiha:liŋ (Bur.) “авьсан”	abisun “авьсан”	li(n) “төрөл сад хүн”	
34.	awudži: (Ord.) “эгч”	*abi “эгч”	*aĵa < *ada “эгч”	
35.	awju:laŋ (Bar.) “авьсан”	*abi “эгч”	li(n) “төрөл сад хүн”	
36.	babaǵa (Tor.) “эхнэр”	*baba “эхнэр”	γa “хүн”	
37.	abai (Mo.) “эхнэр”	*aba “эхнэр”		
38.	abayai (Mo.) “эхнэр”	*aba “эхнэр”	γai “хүн”	
39.	bawa (Mog.) “аав”	*baba “аав”		cf. baba “аав” (T, K.Tat)
40.	ba:bai (Tünk.) “аав”	*baba “аав”		
41.	ba:w (Kal.) “аав”	*baba “аав”		
42.	aba (Bur.), a:ba (Mngr.) “аав”	*baba “аав”		cf. aba “аав” (Alt, Khak, Ev.)
43.	abai (Mo.) > awai (Ord.) “аав”	aba “аав”		

² Нэг айлын хүргэд баз болдог.

³ Монгол хэлэнд нэг айлын хоёр бэрийн ахмадыг нь авьсан, дүүг нь ажин гэдэг.

44.	awi (Dun.) “аав”	*abi “аав”		
45.	abu (Mo.) “аав”	*abi “аав”		
46.	abaya (Mo.) “авга”	aba “аав”	γa “хүн”	
47.	awḡaḡan (Tson.) “авга эгч нар”	abaya “авга”	jin “эмэгтэй”	
48.	awḡalḡan (Bur.) “авга эгч нар”	abaya “авга”	ljin “эмэгтэй”	
49.	baγa: (Ur.) “авга ах”	abaya “авга”		
“be” үе бүтээврийн давталтаас үүссэн нэрс				
50.	ebei (Mo.) “ээж”	*ebe “ээж”		
51.	i:bi: (Tunk.) “ээж”	*ebe “ээж”		
52.	ewe: (Dag.) “ээж”	*ebe “ээж”		
53.	beri (Mo.) “бэр”	*ebe “охин”	üre “үр”	
54.	berge (Üzem.) “бэргэн”	beri “бэр”	ge “хүн”	
55.	bergei (Mo.) “ бэргэн ”	beri “бэр”	ge(i) “хүн”	
56.	bergei (Mo.) “ бэргэн ”	beri “бэр”	ge(n) “хүн”	
57.	ebin (MM.) “авга ах”	*ebi “аав”	-n	
58.	ebüge (Mo.) “өвөг, өвөө”	*ebü “аав”	ge “хүн”	cf. efu “” (Ma.)
59.	bodntsr (Kal.) “хуланц өвөг”	*ebü “аав”	ada “эцэг”/- nčir	
“da” үе бүтээврийн давталтаас үүсэлтэй нэрс				
60.	dä:dä: (Oir.) “аав”	*dada “аав”		cf. dada “эцэг” (Uig, Öz), dedä “эцэг” (AT.)
61.	ad’a: (Oir.) “аав”	*dada “аав”		
62.	aḡa (SY, Üzem.) “эцэг”	*ada “эцэг”		cf. ada “аав” (Öz); ada “эцэг” (Tuv, Khak, Öz.)
63.	- aḡa: (Khor, Cha.) “аав”	*ada “аав”		
64.	- aḡa: (Khal.) “ээж”	*ada “ээж”		
65.	- a:ḡi: (Üzem.) “аав”	*ada “аав”		
66.	ača (Dag.) “эцэг”	*ata “эцэг”		cf. ata “эцэг” (AT, Az Bas, Kaz, Kir, Uz, Tat Uig.)
67.	- ača: (MM.) “эцэг”	ača “эцэг”		cf. aču “эцэг” (AT.)
68.	taγai (MM.) “авга”	*ata “эцэг”	γa(i) “хүн”	
“de” үе бүтээврийн давталтаас үүсэлтэй нэрс				
69.	eḡi (Mo.) “ээж”	*edi “ээж”		
70.	- eḡi: (ÖMon.) “ээж”	eḡi “ээж”		cf. ije “мать, ээж” (Tuv.)
71.	eče: (MM.) “эцэг”	*eče “эцэг”		cf. eče ~ ečeke “бага авга ах” (Nan.)
72.	ečige (Mo.) “эцэг”	*eči “эцэг”	ge/ke “хүн”	

Дүгнэлт

1. Бүтцийн талаас ажиглавал, дээрх анхдагч бүтцүүдийн язгуурт гол төлөв а, е авиа тохиолдож байна. Харин гийгүүлэгч авианы хувьд b, m, n, d/t гийгүүлэгчүүд багтжээ.
2. Утгын талаас үзвэл, анхдагч бүтцүүдийн утга нь ээж → эмэг эх → эгч → эхнэр гэсэн дарааллаар хувьссан байна. Үүнтэй холбогдох түрэг, манж-түнгүс хэлнүүдийн баримтууд нь мөн энэ утгаараа тохирч байна.

Ашигласан толь бичгүүд

1. Баоань хэлний үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 011, ӨМАХХ, 1᠓5, 2᠑᠕ х.
2. Барга аман аялгууны үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 00᠑, ӨМАХХ, 1᠓᠑, 225 х.
3. БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг: Халх аялгуу, 1. Уб., 1᠓᠓, 71᠓ х.
4. Гантогтох, Г., Буриад аялгууны толь, Уб., 2010 (2011), 720 х.
5. Дагур хэлний үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 005, ӨМАХХ, 1᠓4, ᠑᠑7 х.
6. Дунсян хэлний үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 00᠓, ӨМАХХ, 1᠓᠑, 1᠓2 х.
7. Лүнтүү., Ойрд нутгийн аялгууны үгсийн хураангуй, Хөххот, 1᠓4, 246 х.
8. Монгол хэлний үгс, Монгол төрлийн хэл аялгууны судлалын цуврал, 014, ӨМАХХ, 1᠓5, 244 х.
9. Соном., Ордос аман аялгууны үгсийн хураангуй, ӨМҮХХ, 1᠓᠓, 472 х.
10. Төмөртоогоо, Д., Араб үсэгийн монгол дураасгалын судалгаа, Уб., 2002, 172 х.
11. Төмөртоогоо, Д., Монгол дөрвөлжин үсэгийн дураасгалын судалгаа, Уб., 2002, 1᠓2 х.
12. Цолоо, Ж., БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь: Ойрад аялгуу, 2. Уб., 1᠓᠓, ᠓4᠑ х.
13. Цэвэл, Я., Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1᠓66, ᠓11 х.
14. Василевич, Г. М., Эвенкийско-Русский словарь, М., 1᠓5᠓, ᠓0᠑ с.
15. Калмыцко-Русский словарь, М., 1᠓77, 764 с.
16. Магазиник, Д. А., Турецкой-Русский словарь, М., 1᠓45, 705 с.
17. Оненко, Н. С., Нанайско-Русский словарь, М., 1᠓᠓0, 552 с.
18. Пекарский, Э. К., Словарь Якутского языка, 1-᠑, Спб., 1᠓0᠓-1᠓16, 1-12᠓0
19. Поппе, Н. Н., Монгольский словарь Мукаддимат Ал-Адаб, I-II, М-Л., 1᠓᠓, 452 с.
20. Роббек, В. А., Роббек, М. Е., Эвенско-Русский словарь, Новосибирск, 2004, ᠑56 с.
21. Севортян, Э. В., Этимологический словарь тюркских языков, Общетюркские и межтюркские основы на гласные, М., 1᠓74, 76᠓ с.
22. Севортян, Э. В., Этимологический словарь тюркских языков, Б, М., 1᠓74, ᠑4᠓ с.
23. Севортян, Э. В., Этимологический словарь тюркских языков, В, Г и Д, М., 1᠓᠓ с.
24. Сравнительный словарь Тунгусо-Маньчжурских языков, А-Н, 1, Л., 1᠓75, 672 с.
25. Сравнительный словарь Тунгусо-Маньчжурских языков, О-Э, 2, Л., 1᠓77, 471 с.
26. Уйгурско-Русский словарь, Алма-Ата, 1᠓61, ᠑2᠓ с.
27. Федотов, М. Р., Этимологический словарь Чувашского языка, 1, Чебоксары, 1᠓᠓6, 470 с.
28. Karşılaştırmalı Türk Lehçeleri Sözlüğü, I, Ankara, 1᠓᠓1, 11᠓᠑ р.
29. Sun Zhu., Menggu yuzi yan cidian, Qinghai, 1᠓᠓0, ᠓44 р.